

**БАТЛАВ.  
ХУУЛЬ САНААЧЛАГЧ**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Т.ЭНХТҮВШИН**

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

ТУС3764 9023051393 9087184

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж, хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт, татварын таатай орчинг бий болгох, улмаар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхээр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газарт олгосон.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн “Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалт” гэсэн 38 дугаар зүйлийн 38.1.20 дахь заалт болон “Гаалийн болон бусад албан татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлөх” гэсэн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсгийн зохицуулалтыг хугацаагүй гаалийн татвараас чөлөөлөх барааг зохицуулсан уг хуулийн 38 дугаар зүйлд нийцүүлэх, хууль хэрэглээг тодорхой болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулсан.

**Хоёр.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл 2 заалттай. Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж, үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас бүрэн чөлөөлж, паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газарт олгох.

**Гурав.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар:**

Хуулийн төсөл батлагдсанаар Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаанд төрөөс бодлогын болон бусад шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх хууль эрх зүйн орчин бүрдэж, хөрөнгө оруулалт, татварын таатай орчин бий болж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэн үйлдвэрлэлийг цогцолбороор нь хөгжүүлэх боломж бүрдэнэ.

**Дөрөв.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт орох хуулиуд:**

Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр хуульд нэмэлт, өөрчлөлт орохгүй бөгөөд дагалдах хууль батлахгүй.

ХУУЛИЙН ТӨСӨЛ САНААЧЛАГЧ